



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛД
ҮНДЭСЛЭН ОЛГООГҮЙ, ТУХАЙН ЖИЛИЙН БАТЛАГДСАН ТӨСӨВТЭЙ
УЯЛДУУЛАН БАТАЛГААЖУУЛСАН БАЙНА.

АУДИТЫН НЭР: УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ.

АУДИТЫН КОД: ЗАА-2026/05-12/ШТА-НА

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Х.Болдбаатар
Утас: 7046-3783, Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Жалбаа
Утас: 89330330, Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn
Аудитор Н.Цогтсайхан
Утас: 99125745
Цахим хаяг: tsogtsaikhann@audit.gov.mn

Улиастай сум
2026 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	2
ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ.....	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	4
ЗОРИЛТ 1. Өмнөх оноос шилжих зарим төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн төлөвлөлт бодитой бус, төсөвт өртөг, дуусах хугацаанд өөрчлөлт орсон байна.	5-6
ЗОРИЛТ 2. Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих эрх шилжсэн 21 төсөл арга хэмжээ нь өмнөх оноос шилжин хэрэгжиж байгаа тул аудитад хамруулах худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал байхгүй байна.....	6
ЗОРИЛТ 3. Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг бодитоор үнэлээгүй, батлагдсан төсөвтэй уялдуулан хянасан байна.	6-11
ДҮГНЭЛТ.....	12
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ.....	12
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	13
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР.....	13

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХБТХО	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалт

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй</p> <p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2025 оны 05 дугаар тогтоолд тусгасны дагуу хийж гүйцэтгэсэн.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгөн, зөвлөмж боловсруулж дүнг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.</p> <p>Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • <i>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх;</i> • <i>Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьсан эсэх;</i> • <i>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх;</i>
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн ТЕЗ, аймгийн ГХБХБГ, ЗДТГ-ын дэргэдэх бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, тэдгээрийн холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүд, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг гүйцэтгэгч компаниуд, ашиглагч байгууллагуудыг хамруулан, төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд аудитыг хийж гүйцэтгэсэн.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300,400,3000-3100,4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “ Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашигласан.</p>
<p>Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Х.Болдбаатар нар хянан удирдаж, ахлах аудитор Б.Жалбаа, аудитор Б.Мөнхнасан, Н.Цогтсайхан, О.Алтансүвд нар 2026 оны 02 дугаар сарын 25-аас эхлэн 2026 оны 04 дүгээр сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэлээ.</p>
<p>Хүндрэл бэрхшээл</p>	<p>Аудитыг гүйцэтгэх хугацаанд санхүүгийн тайлангийн аудитыг зэрэгцүүлэн гүйцэтгэсэн нь ажлын ачаалал нэмэгдэж цаг</p>

хугацаандаа аудит хийж амжихгүй байх эрсдэлийг бий болгосон .

Аудитын ерөнхий мэдээлэл

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний жагсаалтад 121,898.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл арга хэмжээг Завхан аймгийн ТЕЗ-д эрх шилжүүлсэн байна. Эдгээр төсөл арга хэмжээ нь өмнөх оноос шилжин хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлууд байна.

Зорилт 1. Шилжих зарим төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн төлөвлөлт бодитой бус, төсөвт өртөг, дуусах хугацаанд өөрчлөлт орсон байна.

Орон нутагт эрх шилжсэн 21 төсөл арга хэмжээ нь анх батлагдахдаа 2024-2026 онд хэрэгжиж дуусахаар төлөвлөгдсөн байна. Эдгээр төсөл арга хэмжээний төлөвлөлтийг 3 жилээр судлан үзэхэд дараах төсөл арга хэмжээнүүдийн санхүүжилтийн төлөвлөлт бодитой бус, гэрээний дүнгээс зөрүүтэй байна.

Харин бусад төсөл арга хэмжээний санхүүжилтийг 3 жилд багтаан гэрээний дүнтэй уялдуулан хуваарилсан байна.

Хүснэгт №1 Төсөл арга хэмжээний санхүүжилтийн төлөвлөлт

сая төгрөг

Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг			Санхүүжих дүн				Зөрүү
	2024	2025	2026	2024	2025	2026	Нийт	
Цэцэрлэгийн барилга, 100 ор /Эрдэнэхайрхан сум/	2,615.50	2,589.5	3,586.2	784.7	1,255.4	1,413.9	3,454.0	132.25
Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор / Улиастай сум/	28,285.90	28,285.9	27,584.3	6,485.8	8,900.1	7,006.2	22,392.1	5,192.19
Соёлын төвийн барилга, 200 суудал / Дөрвөлжин сум/	4,512.50	4,490.0	4,490.0	0	1,701.0	2,789.0	4,490.0	(659.0)

Хүснэгтээс харахад:

- ✓ Эрдэнэхайрхан сумын хүүхдийн цэцэрлэгийн барилын ажлын өртгийг мөн 2026 онд нэмэгдүүлсэн байна. Харин санхүүжих дүн нь 132.25 сая төгрөгөөр дутуу төлөвлөгдсөн байна. Энэ нь ТЕЗ төсөвт зохицуулалт хийсэнтэй холбоотой гэсэн тайлбар өглөө.
- ✓ Улиастай суманд баригдаж буй Нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын төсөвт өртгийг гэрээний үнийн дүнгээр баталсан хэдий ч санхүүжих нийт дүн нь

бага байна. Энэ нь тухайн барилга угсралтын ажил анх төлөвлөсөн хугацаанд ашиглалтад орох боломжгүй байх эрсдэлийг бүрдүүлж байна.

- ✓ Дөрвөлжин суманд баригдах Соёлын төвийн барилгын ажлын гэрээний дүн нь магадлалын дүнгээс илүү байсныг улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын үр дүн сэдэвт аудитаар албан шаардлага өгч гэрээний дүнд өөрчлөлт оруулан 3,831.0 сая төгрөг болгон бууруулсан. Гэтэл төсөвт өртгийг бууруулан батлаагүй байна. Мөн 2024 оны санхүүжих дүн тухайн онд олгогдоогүйг 2026 оны санхүүжилтэд нэмж баталсан гэсэн тайлбарыг өглөө. Ингэхдээ гэрээний зөрүүг хасаж батлаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнүүдийн төсөвт өртөг хэлбэлзэлтэй, тогтворгүй байгаа нь анх батлахдаа зураг төсөв болон магадлалын дүгнэлт хийгдээгүй байхад нэг маягийн зураг төсөл болон өөр төсөл арга хэмжээний жишиг магадлалд үндэслэн баталсантай холбоотой байна гэж үзлээ.

Зорилт 2. Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих эрх шилжсэн 21 төсөл арга хэмжээ нь өмнөх оноос шилжин хэрэгжиж байгаа тул аудит хамруулах худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал байхгүй байна.

Зорилт 3. Барилга угсралтын зарим ажлын гүйцэтгэлийг бодитоор хянаагүй, батлагдсан төсөвтэй уялдуулсан байна.

3.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилт он дамжин олгогдсон байна.

Орон нутагт эрх шилжсэн 21 төсөл арга хэмжээний санхүүжилтэд нийт 47,110.5 сая төгрөг батлагдсанаас 38,792.8 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс олгосон нь 8,317.7 сая төгрөгөөр дутуу байна. Энэ нь Сангийн яамнаас хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эрхийг 2025 оны 10 дугаар сараас хойш нээгээгүйтэй холбоотой бөгөөд 2025 оны гүйцэтгэлийн санхүүжилт 6,661.5 сая төгрөгийг 2026 онд олгосон. Ингэхдээ 2026 оны төсөвт батлагдсан санхүүжилтээс олгосон бөгөөд 2026 онд төсвийн тодотгол хийж санхүүжилтийг нэмж батлахгүй бол тухайн төсөл арга хэмжээ төлөвлөгөөт хугацаанд хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүснэ гэсэн тайлбарыг ажил хариуцсан холбогдох мэргэжилтнүүд өглөө.

Улсын төсвөөс олгосон санхүүжилтийг төсөл арга хэмжээ гүйцэтгэгч нарт бүрэн олгосон байна.

Аудитаар орон нутагт эрх шилжсэн төсөл арга хэмжээнүүдийн бодит гүйцэтгэлийг газар дээр нь үзэхэд зарим төсөл арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгоогүй, тухайн онд батлагдсан төсвийг буцаан татуулахгүйн

тулд барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг санхүүжих дүнтэй уялдуулан хянаж, баталгаажуулсан байна гэж үзлээ. Тухайлбал:

- Эрдэнэхайрхан суманд баригдаж буй хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлын бодит гүйцэтгэлийг захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч ГХБХБГ 2025 оны 12 сарын 18-ны байдлаар 64.55 хувийн гүйцэтгэлтэй гэж хянасан нь бодит байдалтай нийцэхгүй байна. Уг төсөл арга хэмжээний гэрээний үнийн дүн 2,589.4 сая төгрөг бөгөөд нийт 1,674.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь гэрээний үнийн дүнгийн 64.6 хувь байна. Аудитаар бодит байдалд барилга угсралтын ажлын гүйцэтгэлтэй танилцахад газар шороо, суурийн ажил хийгдсэн, каркас цутгалт дууссан байдалтай байлаа. Хэрвээ тухайн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг нэмэгдсэн буюу бодит өртөгтэй харьцуулбал 46.7 хувьтай байхаар байна.



- Цагаанхайрхан суманд баригдаж буй Сургуулийн барилгын ажлын гүйцэтгэлийг 2025 оны 11 сарын 13-ны байдлаар 56.4 хувьтай гэж хянасан байна. Гэтэл тус барилгын газар шороо, суурь, каркас цутгалтын ажил дууссан, гадна ханын өрлөгийн ажил эхэлж байна.



- Отгон суманд баригдаж буй Хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлын бодит гүйцэтгэлийг 2025 оны 11 сарын 13-ны байдлаар 66.05 хувийн гүйцэтгэлтэй гэжээ. Гэтэл тус барилгын суурийн ажил хийгдсэн, 1 давхрын каркас цутгасан байдалтай, гэрээний хугацаанд хэрэгжээгүй бөгөөд 2026 онд төсөвт өртөг нэмэгдэж гэрээний хугацааг сунгажээ.



- Тосонцэнгэл суманд баригдаж буй нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөлийн ажлын гүйцэтгэлийг 2025 оны 12 сарын 18-ны байдлаар 55.43 хувийн гүйцэтгэлтэй гэсэн байна. Уг барилга 4 давхар бөгөөд газар шороо, суурь, каркас цутгалтын ажил дууссан, гадна ханын өрлөг 1, 2 дугаар давхар хийгдсэн байдалтай байна.



Дээрх нөхцөл байдлын талаар холбогдох алба хаагчдаас тодруулга авахад:

- Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын алба хаагчид барилгын ажлын гүйцэтгэлийг бодитоор хянан хүргүүлэхэд барилгын ажлын батлагдсан төсвийн гүйцэтгэлтэй зөрүүтэй байна гэсэн шалтгаанаар буцаадаг. Тэрчлэн барилгын ажлыг гүйцэтгүүлэхийн тулд тухайн тайлант онд баталсан санхүүжилттэй уялдуулахаас өөр аргагүй нөхцөл байдал бий болдог байна.
- Аймгийн ЗДТГ-н Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтний тайлбарласнаар зарим төсөл арга хэмжээний төсөвт өртөг магадлалаар батлагдсан төсөвт өртгөөс бага, бодитой бус байгаа нь гүйцэтгэлийг хянахад нөлөөлж байна. Мөн тухайн жилд батлагдсан төсвийг татуулсан нөхцөлд төсөл арга хэмжээний ашиглалтад орох хугацаа сунгагдаж удааширдаг. Иймээс гүйцэтгэлийг санхүүжих дүнтэй уялдуулан гаргаж, гүйцэтгэгч нарыг шахаж төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах хөшүүрэг болгох, тухайн төсөл арга хэмжээний дуусах хугацаанд бодит хяналтыг хийж, гэрээний үүргийн хэрэгжилтийг үнэлж дүгнэх арга хэмжээ авч ажиллаж байна гэсэн тайлбарыг тус тус өглөө.

Холбогдох алба хаагчдын өгсөн тайлбаруудаас дүгнэхэд орон нутагт эрх шилжсэн төсөл арга хэмжээнүүдийн санхүүжилтийн эрхийг мөн орон нутагт шилжүүлж, гүйцэтгэл хангалтгүй төсөл арга хэмжээний санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулж бодит байдалд хяналт тавих, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг анх батлахдаа төсөвт өртгийг бодитой тогтоож, шаардлага хангасан нөхцөлд хэрэгжүүлж эхлэх нь чухал гэдгийг харуулж байна.

Орон нутагт эрх шилжсэн төсөл арга хэмжээнүүдийн санхүүжилтийн эрх орон нутагт шилжихгүй, Сангийн яамнаас санхүүжилтийг барилга угсралтын гүйцэтгэлд үндэслэн олгож байгаа нь зэрэг нь барилга угсралтын ажлын нөхцөл байдалд тодорхой хэмжээний нөлөөлөл үзүүлж байна гэж үзлээ. Өөрөөр хэлбэл батлагдсан санхүүжилт бүрэн олгогддоггүй татагддаг, эргэн олдохдоо хугацаа шаарддаг байна.

Энэ нь барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хийсвэрээр гаргаж санхүүжилт авах, хугацаандаа хийгдээгүй ажлын төсвийг эргүүлэн татуулахгүйн тулд гүйцэтгэлийн хувийг өсгөх эрсдэлүүдийг үүсгэж байна.

Иймд эдгээр эрсдэлийг бууруулж, зөрчлийг арилгахын тулд тухайн төслийн батлагдсан санхүүжилтийг орон нутагт эрх шилжүүлэн бүрэн олгож, захиалагчийн зүгээс хариуцлага хүлээн бодит хяналт тавин гүйцэтгэлийг тухай бүр олгож, төсөл арга хэмжээг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг хууль эрх зүйн хүрээнд авах нь зүйтэй талаарх зөвлөмжийг Сангийн яаманд хүргүүлэх саналтай байна. Ингэснээр захиалагчийн зүгээс бодит хяналт тавих нөхцөл бүрдэж, хариуцлага нэмэгдэнэ гэж үзэж байна.

- Отгон суманд баригдаж буй Соёлын төвийн барилгын угсралтын ажил 2025 онд огт хийгдээгүй байна. Тус барилга 24*38 хэмжээтэй 2 давхар, цутгамал төмөр бетон баганан суурьтай барилга байна. Уг барилга угсралтын ажлын хүрээнд 2024 онд газар шороо, баганан суурийн ажил хийгдсэн бөгөөд тухайн онд батлагдсан төсөв 1,065.6 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон нь барилгын бодит гүйцэтгэлтэй зөрүүтэй байна.



Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2024 оны 12 сарын 20-ны өдрийн хяналтаар барилгын ажлын явц 20 хувийн гүйцэтгэлтэй гэжээ.

Аудитаар тус барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг төсөвт өртөгтэй тулган хянахад 360.1 сая орчим төгрөг байна гэж үзлээ.

Хүснэгт № 2 Барилга угсралтын ажил

сая.төг

д/д	Барилга угсралтын ажлын үе шатны нэр	Нийт өртөг
1	Газар шорооны ажил	90.6
2	Суурийн ажил	194.0
3	Бусад ажил	75.5
ДҮН		360.1

Уг төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны талаар өмнөх оны аудитаар тендер шалгаруулалтыг 3 дахь удаа зохион байгуулахад шаардлагад нийцээгүй тендер ирүүлсэн гэж үнэлсэн “Силикон арт дизайн” ХХК-ийг 4 дэх сонгон шалгаруулалтад оролцоход тус тендер шалгаруулалтын ТББ-т заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаагүй байхад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн гэж үнэлж шалгаруулсан нь үнэлгээний хороо оролцогчдод давуу байдал олгосон, ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй байна гэж дүгнэжээ.

Тендер шалгаруулалтын шаардлага хангаагүй хуулийн этгээдийг сонгон шалгаруулсан нь барилга угсралтын ажил хугацаандаа хийгдэхгүй, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, бусад зориулалтаар ашиглагдах эрсдэлийг бүрдүүлж байна.

Захиалагчийн зүгээс гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцлах талаар мэдэгдэл, албан тоот хүргүүлсэн ч одоог хүртэл шийдэлд хүрээгүй байна.

Иймд уг барилга угсралтын ажлын гүйцэтгэгчид хариуцлага тооцож, барилгын талбайг хамгаалалтад авах, тухайн гүйцэтгэгч цаашид ажлыг үргэлжлүүлэн хийх боломжтой эсэхийг тогтоон мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулан төсөвт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ

- Улиастай суманд баригдаж буй Нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлын явц хэвийн явагдаж байгаа хэдий ч тус барилгын дулааны асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай хүндрэл гарсан байна. Тус барилгын дулааны эх үүсвэрийг Завхан аймагт баригдаж буй дулааны станцаас хангахаар төлөвлөсөн боловч тухайн төсөл арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байгаа нь дээрх нөхцөл байдлыг бий болгосон байна. Захиалагчийн зүгээс төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дулааны асуудлыг шийдэхээр аж ахуй нэгжийг сонгон шалгаруулж, шинэ уурын зуух барихаар шийдвэрлэсэн нь учир дутагдалтай байна. Энэ нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй өвчтөн, эх, нярай хүүхэд, хагалгаа хийлгэсэн хүнд өвчтөн зэрэгт сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Мөн шинэ барилга барих бүрд уурын зуух шинээр барих нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчны бохирдол зэрэгт сөргөөр нөлөөлөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт эрх шилжин хэрэгжиж буй бусад төсөл арга хэмжээний барилга угсралтын ажил хэвийн явагдаж байна. Эдгээр төсөл арга хэмжээний гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг аудитын тайлангийн хавсралт “ерөнхий мэдээлэл”-ээс үзэх боломжтой.

- Дээрх төсөл арга хэмжээнүүдээс гадна өмнөх онуудаас дамжсан, гүйцэтгэл дутуу 4 төсөл арга хэмжээ байна. Үүнд:
 1. Соёлын төвийн барилга, 200 судал /Завхан, Нөмрөг сум/
 2. Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3км /Завхан, Их-уул сум/
 3. Дотуур байрын барилга /Асгат сум/
 4. Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Түдэвтэй сум/

Эдгээр төсөл арга хэмжээ нь анх 2020 онд эхэлсэн бөгөөд төсөв хүрэлцэхгүй гэсэн шалтгаанаар барилга угсралтын ажил удааширч, зогссон байна. Аудитаар төсөл арга хэмжээнүүдийн бодит нөхцөл байдалтай танилцахад Асгат сумын дотуур байр, Түдэвтэй сумын Соёлын төвийн барилга угсралтын ажлуудын нэмэлт төсөв 2026 онд батлагдсан, худалдан авах ажиллааг зарласан байна. Харин Нөмрөг сумын Соёлын төв, Их-уул сумын төвийн авто замын нэмэлт төсвийг магадлалаар оруулан, ҮАГ-аар хянуулан холбогдох яамдууд хүргүүлсэн ч санхүүжилт шийдэгдээгүй байна.

Тухайн төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангуулахгүй удааширснаар өмнө нь гүйцэтгэсэн ажлууд үргүйдэж эвдэрч гэмтэх, дахин нэмэлт хөрөнгө шаардагдах эрсдлийг бий болгож байна.

Өмнөх оноос дамжсан төсөл арга хэмжээнүүдтэй холбоотой барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилт дараах байдалтай байна.

- ✓ Асгат суманд баригдаж буй дотуур байрны ажлын санхүүжилт 63.7 сая, Нөмрөг суманд баригдаж буй Соёлын төвийн барилгын ажлын 70.56 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж,
- ✓ Түдэвтэй суманд баригдаж буй Соёлын төвийн барилга угсралтын ажлын үлдэгдэл санхүүжилт 103.99 сая төгрөг
- ✓ Улиастай суманд баригдсан 800 хүний суудалтай ХЖТ-ын барилгын санхүүжилтэд 968.5 сая төгрөг
- ✓ Отгон суманд баригдаж буй Хүүхдийн цэцэрлэгийг өмнөх оны санхүүжилт 3,250.0 сая төгрөгийг тус тус олгож, 2025 оны жилийн эцсийн байдлаар 1,187.19 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт № 3. Барьцаа хөрөнгийн дансанд үлдэгдэлтэй ТАХ

сая төгрөг

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Мөнгөн дүн /сая.төг/
1	Сумын төвийн хатуу хучилтай авто зам 3км /Завхан, Их-уул/	214.65
2	Хөгжимт жүжгийн театрын барилга /Завхан, Улиастай/	972.54
	ДҮН	1,187.19

3.2 Барилга угсралтын ажлын үе шат бүрд захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Захиалагчийн болон зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн байдалтай танилцахад барилга угсралтын ажилд хяналт хийж, тухай бүр акт үйлдэж фото зургаар баримтжуулсан байна. Хяналт хийсэн тайлан, акт, зургийг хөрөнгө оруулалтын цахим системд мэдээлсэн байна. Хяналт хийх явцдаа барилга байгууламжийн бетоны бат бэх, өрлөгийн ажлын стандартад үзлэг, шалгалт хийсэн байна гэж үзлээ.

Барилга байгууламжийн төсөл арга хэмжээний мэдээллийн самбарын байдалд хяналт хэрэгжүүлээгүй, нийт төсөл арга хэмжээний 14 буюу 66.7 хувь нь мэдээллийн самбаргүй, стандартын бус байна. Уг зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.



Өмнөх аудитаар өгсөн худалдан авах ажиллагаатай холбоотой албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, зөвлөмжийн хэрэгжилт 83.3 хувийн биелэлттэй байна.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн, шинээр хэрэгжих төсөл арга хэмжээ байхгүй тул худалдан авах ажиллагаатай холбоотой албан шаардлагын хэрэгжилтийг орон нутгийн хөрөнгө оруулалтын хүрээнд зохион

байгуулсан худалдан авах ажиллагааны нөхцөл байдалтай уялдуулан хэрэгжилтийг хянан үзэж, дараагийн шатны шийдэл гаргахаар шийдвэрлэлээ.

Өмнөх оны хөрөнгө оруулалтаар “Шинэ хөдөө” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй, тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, хуулийн этгээдэд гэрээгээр эзэмшүүлээгүй байдалд өгсөн дараах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

1. Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийг түрээсээр олгох сонгон шалгаруулалт явуулалгүй шууд гэрээ байгуулсан хуулийн этгээдийн гэрээг цуцалж, сонгон шалгаруулалтыг хийж, шаардлага хангасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулах;
2. Хилийн цэргийн 0277-р ангид олгосон техник, тоног төхөөрөмжийг сумын ЗДТГ-ын эзэмшилд шилжүүлэн, газар тариалан эрхлэгч хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажиллах.

Дүгнэлт:

1. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй батлагдсан зарим төсөл арга хэмжээний санхүүжилтийн төлөвлөлт бодитой бус, төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад орох боломжгүй байдалтай байна.
2. Төсөл арга хэмжээний батлагдсан төсвийг буцаан татуулахгүйн тулд барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг тухайн онд олгох санхүүжилттэй уялдуулан бодит гүйцэтгэлээс зөрүүтэй баталгаажуулсан байна.
3. Төсөл арга хэмжээний батлагдсан төсөвт өртөг бодитой бус байгаа нь барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийн хувь хэмжээг өндөр үзүүлэлттэй харагдуулахад нөлөөлж байна.
4. Шаардлага хангаагүй хуулийн этгээдийг барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан нь төсөл арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.
5. Завхан аймагт баригдаж буй дулааны станцын бүтээн байгуулалтын ажил төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад орохооргүй байгаа нь орон нутагт хэрэгжиж буй зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэл, төлөвлөсөн үр дүнд нөлөөлж байна.
6. Өмнөх онуудад барилга угсралтын ажил нь зогссон төсөл арга хэмжээнүүдийн нэмэлт төсөвт өртөг шийдвэрлэгдэхгүй удаашралтай байна.
7. Төсөл арга хэмжээний мэдээллийн самбарын стандарт, байршуулсан байдалд хяналт хэрэгжүүлж, зохих арга хэмжээ аваагүй байна.

Үндэсний аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах санал:***Сангийн яаманд хүргүүлэх зөвлөмжийн санал:***

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санхүүжих дүнг магадлалын дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дүнтэй уялдуулан төсөвт тусгаж, орон нутагт хэрэгжиж буй төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд дуусгах боломжоор хангаж өгөх
2. Орон нутагт эрх шилжсэн төсөл арга хэмжээний тухайн онд батлагдсан төсвийг орон нутагт эрх шилжүүлэн өгч, барилга угсралтын ажилд бодит хяналт хэрэгжүүлэх боломжийг олгох
3. Завхан аймагт баригдаж буй дулааны станцын ажлын гүйцэтгэл орон нутагт хэрэгжиж буй төсөл арга хэмжээний дулааны асуудалд хүндрэл учруулж байгаад, мөн цаашид хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудад ч нөлөөлж болзошгүй тул анхаарал хандуулах

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд хүргүүлэх зөвлөмжийн санал:

1. Орон нутагт эрх шилжсэн Завхан аймгийн Нөмрөг суманд баригдаж буй Соёлын төвийн барилгын ажлын нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэж, төсөл арга хэмжээг ашиглалтад оруулахад анхаарал хандуулах

Зам, тээврийн яаманд хүргүүлэх зөвлөмжийн санал:

1. Орон нутагт эрх шилжсэн Завхан аймгийн Их-Уул суманд баригдаж буй сумын төвийн хатуу хучилттай авто замын ажлын нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэж, төсөл арга хэмжээг ашиглалтад оруулахад анхаарал хандуулах


Байгууллагаас ирсэн санал:



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
Хатанбаатар Магсаржавын 1-116 тоот
Улиастай сум, Завхан аймаг 81090
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
Цахим шуудан: info@zavkhan.gov.mn
Цахим хуудас: Zavkhan.gov.mn

2026. 04. 30 № 06/453
Талай _____ -ны № _____ Т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт сэдэвт нийцлийн аудитын тайлантай танилцан холбогдох саналаа хавсралтаар хүргүүллээ.
Хавсралт хуудастай.

**БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА**  **ДАЭЖАРГАЛ**



Doc toot a5

8126170505

**УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ СЭДЭВТ НИЙЦЛИЙН АУДИТЫН
ТАЙЛАНГИЙН САНАЛ**

Зорилт 1. Шилжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн төлөвлөлт бодитой бус, төсөвт өртөг, дуусах хугацаанд өөрчлөлт орсон байна.

Орон нутагт эрх шилжсэн 21 төсөл арга хэмжээ нь анх батлагдахдаа 2024-2026 онд хэрэгжиж дуусахаар төлөвлөгдсөн байна. Эдгээр төсөл арга хэмжээний төлөвлөлтийг 3 жилээр судлан үзэхэд дараах төсөл арга хэмжээнүүдийн санхүүжилтийн төлөвлөлт бодитой бус, гэрээний дүнгээс зөрүүтэй байна.

Харин бусад төсөл арга хэмжээний санхүүжилтийг 3 жилд багтаан гэрээний дүнтэй уялдуулан хуваарилсан байна.

1. Отгон суманд баригдах хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын өртгийг 2026 онд нэмэгдүүлсэн байна. Гэтэл санхүүжих дүн нь нэмэгдсэн төсөвт өртгөөс 843.6 сая, магадлалаар хянагдсан дүнгээс 660.5 сая төгрөгөөр тус тус илүү төлөвлөгдсөн байна. Мөн тус арга хэмжээг анх батлахдаа 2025 оны 12 сарын 31-нд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн боловч төлөвлөгөөт хугацаанд барилга угсралтын ажил эхлээгүйгээс гэрээний хугацаанд ажил дуусахааргүй нөхцөл байдал үүссэн байна гэжээ.

- Дээрх барилгын ажил 2024 онд тендер зарлагдаж 2024 онд 5 удаа амжилтгүй болж Зуурмаг ХХК шалгаран гэрээ 2024 оны 11-р сарын 27-ны өдөр байгуулсан. Тухайн онд 1193,5 сая төгрөг батлагдсан бөгөөд тус дүнгээр барьцаа хөрөнгийн дансанд байршуулах хүсэлт Сангийн яаманд хүргүүлсэн боловч 349,9 сая төгрөг байршиж 2025 онд олгогдсон. Үлдэгдэл 843,6 сая төгрөг төсвийн хэмнэлт болсон байхад төсвийн буруу төлөвлөлт гэж үзэх боломжгүй мөн гэрээний дүнгээс нэмж санхүүжүүлээгүй тул хасуулах саналтай. Мөн төсвийн тухай хуулийн дагуу 2026 онд магадлалын ерөнхий дүгнэлт, аудитын дүгнэлтийн дагуу нэмэлт санхүүжилт батлагдаж гэрээг 2026 оны 12-р сарын 25-нд ашиглалтад оруулахаар сунгаж байгуулсан.

2. Эрдэнэхайрхан сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын өртгийг мөн 2026 онд нэмэгдүүлсэн байна. Харин санхүүжих дүн нь 132.25 сая төгрөгөөр дутуу төлөвлөгдсөн байна.

- Анх магадлалаар орсон зураг төсөлгүй төсөв батлагдаж магадлал, төсвийн зөрүү 2026 оны төсөвт батлагдсан.

3. Улиастай суманд баригдаж буй Нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын төсөвт өртгийг гэрээний үнийн дүнгээр баталсан хэдий ч санхүүжих нийт дүн нь бага байна. Энэ нь тухайн барилга угсралтын ажил

төлөвлөгөөт хугацаанд ашиглалтад орох боломжгүй байх эрсдэлийг бүрдүүлж байна.

- Төсвийн тухай хуулиар 2027 онд барилгын ажил дуусахаар батлагдсан учраас тайлангийн хэсгээс хасуулах саналтай. Анх барилга 2026 онд ашиглалтад орохоор батлагдсан боловч 2027 онд дуусахаар төсвийн хуульд заасны дагуу ажил үргэлжилж байна.
- 4. Баянхайрхан суманд баригдах эрүүл мэндийн төвийн барилгын ажлын санхүүжих дүнг гэрээний дүнгээс 600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь үндэслэлгүй байна.**
- Тендер 4 удаа зарлагдаж гүйцэтгэгч оройтож шалгаран хүйтний улиралд ажил хийгдээгүйн улмаас тухайн жилийн санхүүжилт татагдсан тул тайлангийн хэсгээс хасуулах саналтай.
- 5. Дөрвөлжин суманд баригдах Соёлын төвийн барилгын ажлын гэрээний дүн нь магадлалын дүнгээс илүү байсныг улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын үр дүн сэдэвт аудитаар албан шаардлага өгч гэрээний дүнд өөрчлөлт оруулан 3,831.0 сая төгрөг болгон бууруулсан. Гэтэл төсөвт өртгийг бууруулан батлаагүй, санхүүжих дүн нь гэрээний дүнгээс 1,724.7 сая төгрөгөөр илүү байгаа нь үндэслэлгүй байна.**
- Анх 2024 онд гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан боловч 2024 онд ажил хийгдээгүй учраас 1067,5 сая төгрөг олгогдолгүй төсвийн хэмнэлт болсон. Магадлалын ерөнхий дүгнэлтийн дагуу гэрээг 3831,0 сая болгож бууруулан байгуулсан. Нийт гүйцэтгэгчид 1701,0 сая төгрөг олгосон үлдэгдэл 2130,0 сая төгрөг 2026 онд санхүүжиж барилга ашиглалтад орно. Мөн 2026 оны төсөвт батлагдсан 659,0 сая төгрөг төсвийн хэмнэлт болох тул тайлангаас хасуулах саналтай.

3.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх зарим төсөл арга хэмжээний барилга угсралтын ажил зогсонги байдалтай байна.

- Отгон сумын соёлын төвийн барилга гүйцэтгэгчийн буруугаас үүдэн ажил хийгдээгүй бусад барилгын хувьд ажил хэвийн үргэлжилсэн мөн тайланд **Улиастай суманд баригдаж буй Нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлын явц хэвийн явагдаж байгаа хэдий ч тус барилгын дулааны асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай хүндрэл гарсан байна. Тус барилгын дулааны эх үүсвэрийг Завхан аймагт баригдаж буй дулааны станцаас хангахаар төлөвлөсөн боловч тухайн төсөл арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байгаа нь дээрх нөхцөл байдлыг бий болгосон байна.**
- Дээрх дүгнэлт ор үндэслэлгүй бөгөөд 2025 онд дээрх барилгыг дулааны станц ашиглалтад орох хүртэл Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд халаах

аж нэгжийг сонгон шалгаруулсан ажил хэвийн явж байгаа тул тайлангаас хасуулах саналтай байна.

Тайлангийн энэ хэсэгт:

- **Дээрх төсөл арга хэмжээнүүдээс гадна өмнөх онуудаас дамжсан, гүйцэтгэл дутуу 4 төсөл арга хэмжээ байна. Үүнд:**

- 1. Соёлын төвийн барилга, 200 судал /Завхан, Нөмрөг сум/**
- 2. Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3км /Завхан, Их-уул сум/**
- 3. Дотуур байрын барилга /Асгат сум/**
- 4. Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Түдэвтэй сум/**

Эдгээр төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилтийг хангуулахтай холбоотой ажил 2025 онд огт хийгдээгүй бөгөөд Асгат сумын дотуур байр, Түдэвтэй сумын Соёлын төвийн барилга угсралтын ажлуудыг 2026 онд дуусгахаар төсөв батлагдан, худалдан авах ажиллагаа зарласан байна. Нөмрөг сумын Соёлын төв, Их-уул сумын төвийн авто замын нэмэлт хөрөнгийн эх үүсвэр одоо хүртэл шийдэгдээгүй байна гэжээ.

- Асгат сумын дотуур байрын санхүүжилтийн магадлалыг дахин хийж ҮАГ-р хянуулж 2026 оны төсөвт санал өгч тусгуулах
- Түдэвтэй сумын соёлын төвийн нэмэлт ажлын магадлалыг гаргуулж ҮАГ-р хянуулж 2026 оны төсөвт санал өгч тусгуулах
- Нөмрөг сумын соёлын төв, Их-Уул сумын 3 км хатуу хучилттай авто замын төсвийн дахин хийж магадлалаар оруулан ҮАГ-р хянуулсан бөгөөд 2026 оны төсөвт саналаа хүргүүлсэн боловч тусгагдаагүй. Дээрх ажлуудын төсөвлөлтийн шаардлага орон нутгаас хамаарах бүхий л ажлыг хийж төсөвт санал хүргүүлсэн тул аудитын дүгнэлтийг энэ хэсгийг хасуулах, аль эсвэл засуулах саналтай байна.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Төрийн аудитын газраас шийдвэрлэсэн байдал:

д/д	Ирүүлсэн санал тайлбар	Төрийн аудитын газрын шийдвэр
1	<p>Отгон суманд баригдах хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын өртгийг 2026 онд нэмэгдүүлсэн байна. Гэтэл санхүүжих дүн нь нэмэгдсэн төсөвт өртгөөс 843.6 сая, магадлалаар хянагдсан дүнгээс 660.5 сая төгрөгөөр тус тус илүү төлөвлөгдсөн байна. Мөн тус арга хэмжээг анх батлахдаа 2025 оны 12 сарын 31-нд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн боловч төлөвлөгөөт хугацаанд барилга угсралтын ажил эхлээгүйгээс гэрээний хугацаанд ажил дуусахааргүй нөхцөл байдал үүссэн байна.</p> <p>Тайлбар: Дээрх ажил нь 2024 он буюу төлөвлөгөөт хугацаандаа эхлээгүй бөгөөд тухайн онд батлагдсан 1,193.5 сая төгрөгөөс 349.9 сая төгрөг барьцаа хөрөнгийн дансанд байршиж 843.6 сая төгрөг татагдсан. Уг татагдсан төсвийг 2026 оны санхүүжих дүнд оруулан баталсан нь санхүүжих дүнг илүү мэт харагдуулж байна. Иймд тайлангаас хасуулах саналтай байна.</p>	<p>Саналыг хүлээн авч аудитын тайлангаас хасахаар шийдвэрлэлээ</p>
2	<p>Эрдэнэхайрхан сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын өртгийг мөн 2026 онд нэмэгдүүлсэн байна. Харин санхүүжих дүн нь 132.25 сая төгрөгөөр дутуу төлөвлөгдсөн байна.</p> <p>Тайлбар: Анх магадлалаар орсон зураг төсөлгүй төсөв батлагдаж магадал, төсвийн зөрүү 2026 оны төсөвт батлагдсан. Иймд тайлангаас хасуулах саналтай байна.</p>	<p>ТЭЗ төсөвт зохицуулалт хийсэн холбоотой гэсэн нэмэлт тайлбар өгсөн тул тайланд уг тайлбарыг оруулан засварлалаа.</p>
3	<p>Улиастай суманд баригдаж буй Нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын төсөвт өртгийг гэрээний үнийн дүнгээр баталсан хэдий ч санхүүжих нийт дүн нь бага байна. Энэ нь тухайн барилга угсралтын ажил анх төлөвлөсөн хугацаанд ашиглалтад орох боломжгүй байх эрсдэлийг бүрдүүлж байна.</p> <p>Тайлбар: Монгол улсын 2026 оны Төсвийн тухай хуулиар 2027 онд барилгын ажил дуусахаар батлагдсан учраас тайлангийн хэсгээс хасуулах саналтай байна. Тус барилга анх 2026 онд ашиглалтад орохоор батлагдсан тул тайлангаас хасуулах саналтай байна.</p>	<p>Тухайн барилга угсралтын ажил нь анх төлөвлөсөн буюу 2024 онд эхэлсэн, гүйцэтгэгч төлөвлөгөөт ажлаа хэвийн явуулж байхад санхүүжилтийг 4 жилд хуваан төлөвлөж, ашиглалтад орох хугацааг сунгасан нь үндэслэлгүй байна гэж үзсэн тул саналыг хүлээн авах боломжгүй байна.</p>

4	<p>Баянхайрхан суманд баригдаж буй ЭМТ-ийн барилгын ажлын санхүүжих дүнг гэрээний дүнгээс 600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь үндэслэлгүй байна.</p> <p>Тайлбар: Анх ажил он буй 2024 онд ажил хийгдээгүйгээс тухайн жилд батлагдсан санхүүжилт татагдсан. Уг татагдсан санхүүжилтийг 2026 оны төсөвт нэмж батлуулсан тул тайлангаас хасуулах саналтай байна.</p>	<p>Саналыг хүлээн авч аудитын тайлангаас хасахаар шийдвэрлэлээ</p>
5	<p>Дөрвөлжин суманд баригдах Соёлын төвийн барилгын ажлын гэрээний дүн нь магадлалын дүнгээс илүү байсныг улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын үр дүн сэдэвт аудитаар албан шаардлага өгч гэрээний дүнд өөрчлөлт оруулан 3,831.0 сая төгрөг болгон бууруулсан. Гэтэл төсөвт өртгийг бууруулан батлаагүй, санхүүжих дүн нь гэрээний дүнгээс 1,724.7 сая төгрөгөөр илүү байгаа нь үндэслэлгүй байна.</p> <p>Тайлбар: Анх 2024 онд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан боловч ажил хийгдээгүй учраас тухайн онд батлагдсан санхүүжилт 1,067.5 сая төгрөг татагдсан бөгөөд уг төсвийг 2026 оны төсөвт нэмж баталсан тул тайлангаас хасуулах саналтай байна.</p>	<p>Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийн үр дүн тул саналыг хүлээн авах боломжгүй байна. Ирсэн санал тайлбарт үндэслэн утга найруулгын засвар оруулахаар шийдвэрлэлээ</p>
6	<p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх зарим төсөл арга хэмжээний барилга угсралтын ажил зогсонги байдалтай байна.</p> <p>Тайлбар: Дээрх дүгнэлт үндэслэлгүй бөгөөд Отгон сумын Соёлын төвийн барилга гүйцэтгэгчийн буруугаас үүдэн ажил хийгдээгүй, бусад барилгын хувьд ажил хэвийн явагдаж байгаа тул тайлангаас хасуулах саналтай байна.</p>	<p>Орон нутагт хэрэгжиж буй бүх төсөл арга хэмжээний хэрэгжилт зогсонги байдалд орсон байдлаар дүгнээгүй тул саналд үндэслэн утга найруулгын засвар хийхээр шийдвэрлэлээ.</p>
7	<p>Улиастай суманд баригдаж буй Нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлын явц хэвийн явагдаж байгаа хэдий ч тус барилгын дулааны асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай хүндрэл гарсан байна. Тус барилгын дулааны эх үүсвэрийг Завхан аймагт баригдаж буй дулааны станцаас хангахаар төлөвлөсөн боловч тухайн төсөл арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байгаа нь дээрх нөхцөл байдлыг бий болгосон байна.</p> <p>Тайлбар: Уг барилгыг дулааны станц ашиглалтад орох хүртэл Төр хувийн хэвшлийн</p>	<p>Тус барилга нь томоохон бүтээн байгуулалт бөгөөд уг барилгыг халаах хүчин чадал бүхий хуулийн этгээд байхгүйн улмаас шинээр уурын зуух барихаар шийдвэрлэсэн нь учир дутагдалтай бөгөөд цаашид төсвөөс нэмэлт зардал гарах эрсдэлийг бий болгож байна. Нэгдсэн эмнэлгийн ойр орчимд уурын зуух олноор барих нь /хуучин уурын зуух нь байгаа</p>

	<p>түншлэлийн хүрээнд халаах аж ахуй нэгжийг сонгон шалгаруулсан, ажил хэвийн явж байгаа тул тайлангаас хасуулах саналтай байна.</p>	<p>болно/ эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй өвчтөн, эх, нярай хүүхэд, хагалгаа хийлгэсэн хүнд өвчтөн зэрэгт сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Мөн шинэ барилга барих бүрд уурын зуух шинээр барих нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчны бохирдол зэрэгт сөргөөр нөлөөлөх тул саналыг хүлээн авах боломжгүй байна. Ирсэн саналд үндэслэн тайланд утга найруулгын засвар хийж, ҮАГ-ын нэгтгэсэн тайланд тусгуулах зөвлөмжид оруулахаар шийдвэрлэлээ.</p>
8	<p>Дээрх төсөл арга хэмжээнүүдээс гадна өмнөх онуудаас дамжсан, гүйцэтгэл дутуу 4 төсөл арга хэмжээ байна. Эдгээр төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилтийг хангуулахтай холбоотой ажил 2025 онд огт хийгдээгүй бөгөөд Асгат сумын дотуур байр, Түдэвтэй сумын Соёлын төвийн барилга угсралтын ажлуудыг 2026 онд дуусгахаар төсөв батлагдан, худалдан авах ажиллааг зарласан байна. Нөмрөг сумын Соёлын төв, Их-уул сумын төвийн авто замын нэмэлт хөрөнгийн эх үүсвэр одоо хүртэл шийдэгдээгүй байна.</p> <p>Тайлбар: Уг ажлуудын хүрээнд орон нутгаас хамаарах ажлыг хийсэн тул тайлангийн утга найруулгыг засуулах саналтай байна.</p>	<p>Аудитын тайланд орон нутгаас хийсэн ажлуудыг дурдсан бөгөөд ирсэн саналд үндэслэн утга найруулгын засвар хийхээр шийдвэрлээ</p>

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР